



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 4/09

Арвайхээр

Хувь хүний орлогын албан татварын
буцаан олголт авах татвар төлөгчдийн
жагсаалт батлах тухай


Монгол Улсын Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Татварын ерөнхий хуулийн 49 дүгээр зүйл, 2006 оны 06 дугаар сарын 16-ны өдөр баталсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12 дугаар заалт, 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр баталсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн /Шинэчилсэн найруулга/-ын 23 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 19 дугаар тушаалаар батлагдсан "Илүү төлсөн албан татварыг буцаан олгох, хяналт тавих, нягтлан бодох бүртгэлд тусгах журам"-ын 2.7 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Татвар төлөгчийн 2023 оны хүлээн авч, баталгаажуулсан албан татварын тайлан, татвар төлөгчийн илүү төлөлтөө буцаан авах хүсэлтийг үндэслэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэгт заасан "Хөнгөлөлтийн дагуу буцаан олголт авах татвар төлөгчийн жагсаалт"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтад дурьдсан нэр бүхий 1397 татвар төлөгчид буцаан олгох 1,639,054,606.66 (Нэг тэрбум зургаан зуун гучин есэн сая тавин дөрвөн мянга зургаан зуун зургаан төгрөг жаран зургаан мөнгө)-ний буцаан олголтын жагсаалтыг Өвөрхангай аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэхийг Бичил татвар төлөгчтэй харилцах тасагт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга (Ц.Цэнд-Аюуш)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ЭРДЭНЭСУВД

621001017
D.Alban bichig Tushaal 2024



**ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ,
ЧӨЛӨӨЛӨЛТИЙН ИЛҮҮ ТӨЛӨЛТ БУЦААН ОЛГОХ ЖАГСААЛТ**

2024.03.19

№	Сумын нэр	2023 он	
		Татвар төлөгчийн тоо	Буцаан авах дүн
1	Баян-Өндөр	26	16,628,887.77
2	Бүрд	16	17,270,262.03
3	Бат-Өлзий	30	43,164,466.69
4	ББУлаан	13	13,501,263.55
5	Баянгол	38	49,007,762.40
6	Гучин	12	22,155,777.97
7	Зүйл	13	16,404,802.75
8	Өлзийт	28	31,180,345.75
9	ЗБУлаан	17	15,524,006.78
10	Хайрхандулаан	31	31,844,566.18
11	Нарийнтээл	31	45,672,206.24
12	Сант	25	24,272,307.23
13	Тарагт	22	19,160,560.65
14	Төгрөг	30	37,975,290.64
15	Уянга	43	41,306,573.75
16	Богд	24	25,680,396.92
17	Хужирт	48	36,442,359.76
18	ХХорин	179	179,110,211.95
19	Арвайхээр	771	972,752,557.65
Нийт		1,397	1,639,054,606.66

ЖАГСААЛТ ГАРГАСАН:
ОРЛОГЫН ХЯНАЛТ БУЦААН ОЛГОЛТ
ХАРИУЦСАН ТУБ *Лхамсүрэн* Э.ЛХАМСҮРЭН

ХЯНАСАН:
БИЧИЛ ТАТВАР ТӨЛӨГЧТЭЙ
ХАРИЛЦАХ ТАСГИЙН ДАРГА *Ц.ЦЭНД-АЮУШ*

